



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/183

Улаанбаатар хот

Онцгой нөхцөл байдал үүссэн үед
зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 358 дугаар тогтоолын 2.5.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зам, тээврийн салбарын аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг зохицуулах, зохион байгуулах, ослоос урьдчилан сэргийлэхтэй холбогдуулан салбарын хэмжээнд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд шуурхай арга хэмжээ зохион байгуулж, харилцан уялдаатай ажиллахыг холбогдох газар, хэлтсийн дарга болон харьяа газрын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

2.Онцгой нөхцөл байдал үүссэн үр дагаврыг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахтай холбогдуулан инженер техникийн ажилтан, шуурхай бүлгийн машин тоног төхөөрөмжөөр хангаж, холбогдох зардлыг тухай бүр шийдвэрлэж ажиллахыг харьяа газрын дарга, захирал нарт даалгасугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (М.Энхболд)-т үүрэг болгосугай.

САЙД  Л.ХАЛТАР

0200000556